

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ

(2024 оны эхний хагас жил)

№	Шийдвэрийн огноо, дугаар, нэр	Заалтын агуулга	Хэрэгжилт	Үнэлгээ
НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ				
10	2023.03.30 №39 Тогтоол хүчингүй болгох тухай	2.Хууль тогтоомж шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлын талаар тухай бүр өргөн мэдүүлж хэлэлцүүлж ажиллахыг Нийслэлийн Засагдарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.	<p>Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай болон дагалдан гарсан хуульд тусгагдсаны дагуу холбогдох дүрэм, журам, шийдвэрийг боловсруулах ажлыг эхлүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор дараах захиргааны хэм хэмжээний актыг боловсруулан батлуулж, улсын нэгдсэн санд бүртгүүлэн дагаж мөрдөж байна:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сан байгуулах, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам; 2. Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн хэрэгцээний авто зогсоолыг төлөвлөх, барьж байгуулах журам; 3. Нийслэл хотод олгох тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дээд хязгаар тогтоох тухай; 4. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хэмжээг батлах тухай; 5. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор Нийслэлийн нутаг дэвсгэрт мөрдөх таксинаас бусад нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг баталсан. Нийтийн тээврийн төлбөрийн шинэ системийн хөгжүүлэлтийн ажил хийгдэж байгаатай уялдуулан 2024 оны 4 дүгээр улиралд багтаан тогтоолын хэрэгжилтийг мөрдүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 6. Амьтны хүрээлэн ажиллуулах журам; 	

			<p>7. Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарыг тогтоож, Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд нэвтэрсэн малыг түр хадгалах, түүнтэй холбогдон гарсан зардлыг нөхөн төлүүлэх журам;</p> <p>8. Оршуулгын үйл ажиллагаа эрхлэх, зохион байгуулах, зөвшөөрөлтэй оршуулгын газар болон зөвшөөрөлгүй газар оршуулсан шарилыг шилжүүлэх журам;</p> <p>9. Авто зам ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай.</p>	
12	2023.03.30 №42 Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй дэд бүтцэд хамаарах хотын стандартыг батлах тухай	2.Батлагдсан хотын стандартыг олон нийтэд сурталчлан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д үүрэг болгосугай	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй дэд бүтэц бүлэгт хамаарах 2 хотын стандартыг www.standard.ub.gov.mn цахим хуудсанд байршуулж, олон нийтэд сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - “Эрүүл мэндийн байдлаар ялгаварлан гадуурхахаас хамгаалах холбоо”-оос ирүүлсэн хүсэлтийн дагуу Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороонд байрлах Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн харьяа Сэргээн засах төв эмнэлгийн гадна орчины хүртээмжийг хяналт хийж ажиллав. - Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/128 дугаар захирамжаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд саадгүй оролцох боломжийг бүрдүүлэх зорилгоор төрийн байгууллага, нийтийн тээврийн автобусны зогсоолын стандартыг хангуулах” үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Тус Ажлын хэсэг Нийтийн тээврийн автобусны зогсоолын стандартын хэрэгжилтэд хийсэн судалгаагаар дараах үр дүнг тодорхойлсон. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн хэмжээнд нийт – 1170 автобусны зогсоол - Шилэн фасадтай автобусны зогсоол – 207 зогсоол байна. Үүнээс: - Стандартын шаардлагыг 70 хувиас дээш хангасан - 128 зогсоол - Стандартын шаардлага хангахгүй - 93 зогсоол байна. /хөтөч хавтан, анхааруулах хавтангүй, явган замын хашлага хэт өндөр,налуу замгүй, зайн хэмжээс алдагдсан гэх мэт../ <p>Дээрх үр дүнд үндэслэн нийт 37 автобусны зогсоолыг ХБИ-нд хүртээмжтэй болгон шинэчлэн засах ажлыг “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах нийслэлийн салбар зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусган сайжруулахаар ажиллаж байна.</p>	
41	2024.02.08 №03 Нийслэлийн нийтийн	1.”Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих	<p>2020 оноос өмнөх онуудад авсан автобусны төлбөрийн үлдэгдэл 4,218.8 сая төгрөгөөс 2024 оны 2-р улиралд Автобус нэгдэл ХХК 20,0 сая төгрөг, Сутайн буянт ХХК 131,7 сая төгрөг, Эрдэмтранс ХХК 76,2 сая төгрөг, нийт 227,9 сая төгрөг төвлөрүүлээд байна.</p>	100

	тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам батлах тухай	журам"-ыг хавсралтаар баталсугай.	Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч хувийн аж ахуйн нэгжүүдтэй тээврийн хэрэгсэл төлбөртэй ашиглах гэрээг байгуулж гэрээний дагуу сар бүрийн төлөлтийг, мөн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудаас элэгдлийг зардлыг тус тус санхүүжилтээс суутган ажиллаж байна. 2024 оны 3 дугаар сарын санхүүжилтээс 2,6 тэрбум төгрөг, 4 дүгээр сараас 2,9 тэрбум төгрөг, 5 дугаар сараас 3.0 тэрбум төгрөг, 6 дугаар сараас 3.0 тэрбум төгрөг, нийт 11.5 тэрбум төгрөгийг Нийтийн тээврийг хөгжүүлэх санд төвлөрүүлэн журмын дагуу хяналт тавин ажиллаж байна.
48	2024.02.08 №10 "Иж бүрэн гудамж" бүлэгт хамаарах хотын стандартад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах зорилтын хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Иж бүрэн гудамж" бүлэгт хамаарах "Тээврийн хэрэгслийн зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавих ерөнхий шаардлага" хотын стандартын дараах хэсэгт дор дурдсан нэмэлт, өөрчлөлтийг оруулж баталсугай	Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Нийтийн тээврийн салбартай холбоотой стандартад нэмэлт өөрчлөлт оруулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжид 21 дүгээр хуралдаанаар хэлэлцэн батлав. Үүнд: UCS 0902B:2022 "Тээврийн хэрэгслийн зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавих ерөнхий шаардлага"-ын стандартад Цахилгаан тээврийн хэрэгслийн зогсоол, Зогсоол хоорондын зайн хэмжээстэй холбоотой нэмэлт өөрчлөлт оруулав.
49	2024.02.08 №11 Зорчигч тээврийн үйлчилгээ" бүлэгт хамаарах хотын стандартад нэмэлт,	1,Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилтын хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Зорчигч тээврийн үйлчилгээ" бүлэгт хамаарах "Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавигдах ерөнхий шаардлага" хотын стандартын	Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Нийтийн тээврийн салбартай холбоотой дараах 2 хотын стандартад нэмэлт өөрчлөлт оруулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжид 21 дүгээр хуралдаанаар хэлэлцэн батлав. Үүнд: UCS 1601B:2022 "Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавих ерөнхий шаардлага"- Автобусны бичиглэл, өнгөний асуудалтай холбоотой нэмэлт өөрчлөлт оруулав.

	өөрчлөлт оруулах тухай	дараах хэсэгт дор дурдсан нэмэлт, өөрчлөлтийг оруулж баталсугай.	UCS 1603B:2022 “Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага”-Нийтийн тээврийн хэрэгслийн өнгө, зогсоолын бичиглэлд нэмэлт өөрчлөлт оруулав.	
73	2024.04.29 №52 Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай	1.Эрүүгийн 2302006440349 тоот хэрэгт гаргасан нэхэмжлэл, “Тэнүүн-огоо” ХХК болон Нийслэлийн Нийтийн тээврийн газрын хооронд 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан “Төлбөр барагдуулах хэлцэл”-ийн дагуу нийт 75,377,504,176.00 (далан таван тэрбум гурван зуун далан долоон сая таван зуун дөрвөн мянга нэг зуун далан зургаа) төгрөгийн өртөг бүхий, хавсралтад заасан хөрөнгийг нийслэлийн өмчид хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.	Нийслэлийн Засаг даргын 2024.05.10-ны өдрийн А/543 дугаар захирамжаар “Төлбөр барагдуулах хэлцэл”-ийн дагуу нийт 75,377,504,176.00 (далан таван тэрбум гурван зуун далан долоон сая таван зуун дөрвөн мянга нэг зуун далан зургаа) төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг нийслэлийн өмчид хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн, ашиглалт хамгаалалтыг хариуцан тогтоол, захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны 2/854 тоот албан бичгээр “Зорчигч тээвэр тав” ОНӨААТҮГ-т, 2024 оны 2/853 тоот албан бичгээр Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газарт тус тус мэдэгдсэн. Үүнд: <ol style="list-style-type: none"> 1. Төв бааз 2. Хоёрдугаар бааз 3. Гуравдугаар бааз 4. Дөрөвдүгээр бааз тус тус нийслэлийн өмчид бүртгэсэн.	100